

“БАТЛАВ:

БОАЖЯ-ны

Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн

удирдлагын газрын дарга:

А. Энхбат

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ийн

Уурхайн захирал

Ц. Ганзориг

**ӨМНӨГОВЬ АЙМАГ, НОЁН СУМЫН
“БАНУУН НОЁН УУЛ” НЭРТЭЙ НҮҮРСНИЙ
ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ АШИГЛАЛТЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР-МV-017301/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР-5671833/

ХЯНАСАН: БОАЖЯ-ны ХБОБНУГ-ны

Ахлах шинжээч:

Ц. Жаргалнэмэх

Тайлан боловсруулсан:

Байгаль орчны мэргэжилтэн

М. Дуламжав

ГАРЧИГ

1. Товч танилцуулга	4
2. “Баруун ноён уул” нүүрсний уурхайн байгаль орчны төлөв байдал	6
2.1 Төсөл хэрэгжих орчны өнөөгийн төлөв:	6
2.2 Төслийн гол ба болзошгүй нөлөөлөл:	11
3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний	16
3.1 Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ:	17
3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө:	21
3.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө:	22
3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө:	23
3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө:	24
3.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө:	25
3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө:	26
3.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр:	28
3.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө:	30
3.10 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө:	32

ЗУРГИЙН ТАЙЛБАР

Зураг 1. Ашиглалтын талбайн ландсатын зураг	4
Зураг 2. Ашиглалтын талбайн байршил	5
Зураг 3. Талбайн хөрсний зураг	7

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Ашиглалтын талбайн газарзүйн солбилцолын цэгүүд	4
Хүснэгт 2. Гол болон болзошгүй нөлөөлөл	11
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
Хүснэгт 6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	23
Хүснэгт 7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	26
Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	28
Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	30
Хүснэгт 12. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	32
Хүснэгт 13. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал	33


1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уурхайн байршил: “Баруун ноён уул” нэртэй ашигт малтмалын ашиглалтын MV-017301 дугаарын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Өмнөговь аймгийн Даланзадгад хотоос баруун зүгт ойролцоогоор 210 км, тус аймгийн Ноён сумын төвөөс зүүн тийш 30 км зайд байрлана.


Ашигт малтмал ашиглалтын MV-017301 дугаартай талбайн нийт хэмжээ 1085.20 га бөгөөд талбайг хамрах 6 цэгийн солбилцолтой.

Хүснэгт 1. Ашиглалтын талбайн газарзүйн солбилцолын цэгүүд

№	Уртраг	Өргөрөг
1	102° 23' 4.9"	43° 6' 0.26"
2	102° 23' 4.9"	43° 5' 29.58"
3	102° 30' 0.89"	43° 5' 29.58"
4	102° 30' 0.89"	43° 5' 1.29"
5	102° 22' 0.8"	43° 5' 1.31"
6	102° 22' 0.8"	43° 6' 0.26"



Зураг 1. Ашиглалтын талбайн лансатын зураг



Зураг 2. Ашиглалтын талбайн байршил

2. “БАРУУН НОЁН УУЛ” НҮҮРСНИЙ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Төсөл хэрэгжих орчны өнөөгийн төлөв:

Уур амьсгал:

Нүүрсний орд орчмын нутаг дэвсгэр нь цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай, тогтворгүй чиглэлийн салхитай, өвөлдөө цас багатай, хүйтний эрч бага, хавар хүйтэвтэр, шороон шуурга элбэг, зундаа хуурай халуун уур амьсгалтай болох нь Ноён сумдын цаг уурын олон жилийн ажиглалт, мэдээнээс тодорхой байна. Тухайлбал: Агаарын дундаж температур Ноён сумын нутгаар $3.5-4.0^{\circ}\text{C}$, хооронд хэлбэлздэг байна.

Агаарын үнэмлэхүй бага хэм – 40.0° , мөн үнэмлэхүй их хэм 39.8° байна. Хамгийн эхний хүйтрэлт IX сарын сүүлч, XI сарын эхээр болно. Хүйтний саруудад XI-II сарыг дуустал үргэлжилнэ. II сарын сүүлчээс мэдэгдэхүйц дулаарч эхэлнэ. Дулааны улирлын хамгийн их халуун нь VIII дугаар сард болж 39.8° хэм хүрдэг. Хамгийн хүйтэн сар I сард -23° хэм болно. Хөрсний хөлдөлт 0.8-1.8 м. Хоногийн дундаж хэм нь 00°C -ээс доош байх үеийн өдрийн тоо 153 юм. Цас орой унаж (XII сарын сүүлч I сарын эхээр) хавар эрт (II сарын сүүлчээр) хайлна. Цасан бүрхүүлийн үнэмлэхүй зузаан нь 16 см. Энд хур тунадасны уналт их биш, жилийн дундаж хур тунадас 82.4 мм. Үүний 60 хувь нь зуны улиралд ордог байна.

Газрын гадаргуугын байдал:

Энэхүү талбай нь газрын гадаргын хувьд Говь-Алтайн уулсын дундах тал хээрийн бүсэд орших ба ихэнх хэсэг нь бэсрэг уулс толгодорхог гадаргуутай газруудыг хамаарна. Түр зуурын усаар тэжээгддэг жижиг худаг г.м уст цэгүүдтэй. Харин физик газар зүйн мужлалын хувьд Алтайн уулархаг их мужийн Говь Алтайн мужийн Говь Алтайн зүүн тойрогт багтдаг.

Талбайн геологийн тогтоц:

Тусгай зөвшөөрлийн талбай нь тектоник мужлалын хувьд Өмнөд Монголын герциний атираат мужийн өмнөд хэсэгт Хашаатын бүсэнд хамаарагдана. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн орчимд дунд палеозойгоос орчин үеийн хүртэлх насны давхараат хурдас болон хожуу палеозой, түрүү юрагийн настай гүний чулуулаг тодорхой структуруудад их бага хэмжээгээр тархсан байна.


Тус төслийн талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн дэд муж дахь Говь-Алтайн зүүн тойрогт багтах бөгөөд хойгуураа Говь-Алтайн нурууны салбар уул, нурууд болох Их Сэврэй уул, Зөөлөнгийн нуруу, Шар тал, Жарангийн элс, зүүн урд талаараа Тахилгат Овоо уул (д.т.д. 1975.0 м), Уурт хайрхан уул (д.т.д. 1634.0 м), Бүгтийн хоолой, Цоогондойн тал, зүүн талаараа Их Хонгор уул (д.т.д. 1571.0 м), Хар овооны тал,

баруун талаараа Хүрэн Ханангийн нуруу, Эрдэнэ нуруу, Тахилга уул (д.т.д. 2323.0 м) өмнөд талаараа Эхэн Хайласт уул (д.т.д. 1813.0 м) зэрэг уул, нурууд, элст хотгор, тал, хөндий, хоолойгоор хүрээлэгдэнэ. Гадаргын дундаж өндөр нь д.т.д 1737.6 м орчим, хамгийн өндөр цэг хайгуулын талбайн зүүн талд орших д.т.д 1975.2 метр өндөртэй ноён оргил болох Тахилга уул бол хамгийн нам цэг нь талбайн баруун хойд талд Дөрвөлжин уулын (д.т.д. 1612.1 м) өвөр бэлд орших Жарангийн элстийн хотгор (д.т.д 1500.1 м) юм.

Хөрс:

Төслийн талбай орчмын нутгийн хөрс нь Монгол орны байгалийн бүсийн хуурай хээр, заримдаг цөлийн бүсэд хамрагдах бөгөөд энэхүү байгалийн бүсийн зүй тогтол, хотгор гүдгэр, уур амьсгалын нөхцөл байдлаас хамаараад говь, цөлийн, хуурай хээрийн бор, саарал, борзон зэрэг хөрсний хэв шинжүүд тархсан байна. Судалгааны талбайн хөрс бүрхэвч нь доорхи 2 хэв шинжийн ангилалд хуваагдаж байна.

1. Говийн цайвар бор хөрс
2. Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс таржээ.



Зураг 3. Талбайн хөрсний зураг

Газрын гадарга, усан сүлжээ:

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших MV-017301 ашиглалтын талбай орчмын нутаг нь дэлхийн гадаргын усны ай савын мужлалаар Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагдах бөгөөд тогтмол урсацтай гол, горхи, нуур, цөөрөм байхгүй гадаргын ус ховортой бүсэд багтана. Энд зөвхөн уулс хоорондын хотгорт жижиг шал, тойром бүхий газарт хур бороо ихтэй үед уулсын

жигжиг ам, хөндий хуурай сайраар түр зуурын урсац бүхий ус урсаж хотгоруудын ёроолд хурж тогтох ба сэвсгэр хурдсан доогуур шурган замхардаг. Нөгөөтэйгүүр ашиглалтын талбай нь Монгол орны өмнөд хэсэг хуурай хээр, цөлийн бүсэд багтдаг учир жилийн дундаж хур тунадасны хэмжээ 60 -100 мм байна.

Гадаргын усны сүлжээний нягтаршил нь нэг ам дөрвөлжин км талбайд 0,01 мм- ээс бага, хур борооны үерийн хамгийн их урсац 10 мм-ээс бага, шар усны үерийн хамгийн их урсац 4 мм-ээс бага байна. Харин энд зарим уулсын хажуугаас цөөн тооны гүний усны ундрага булаг, шанд оргилон гарна. Үүнд: Ашиглалтын талбайн дунд хэсэг Эхэн Хайлааст (далайн түвшнээс дээш 1813.0 м) уулын ар хажуугийн бэлд, Жарангийн элст хотгорт ундран гарах Сайрын худаг, Гашууны худаг талбайн зүүн талд Тахилга уулын (далайн түвшнээс дээш 1975.2 м) ар бэл, хормойд Сүвээт зэрэг цөөн тооны худаг бий. Гадаргын ус ховор, уулын хормой бэл, уулс дотоодын хотос, хонхорт газрын доорх гүний ус элбэгтэй тул малчид эрт дээр үеэс худаг гарган хүн малын ундны хэрэгцээнд хэрэглэсээр ирсэн уламжлалтай бөгөөд газрын доорх усны статик түвшний хэлбэлзэл нь газрын гадаргаас доош 1.23- 22 метр хүртэлх гүнд байна

Ургамлан нөмрөг:

Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Өмнөговь аймаг нь Говь- алтайн уулын цөлөрхөг хээр, Алаша говь, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг. Ургамлын зүйлийн бүрдлийн 21,4% нь хуурайсаг, 21,3% нь хуурайсуу- чулуусаг, 15,5% нь чийгсүү-давссаг, 10,2% нь чийгсүү-хуурайсаг, 6,5% нь элсэн дасалттай ургамал бөгөөд сөөг, сөөгөнцөр ургамлын бүлгэмдэл зонхилно. Үүнд: өдлөг хялганат (монгол өвст) бүлгэмдэл элбэг тохиолдох ба Говийн хялгана (*Stipa gobica*), Сайрын хялгана (*Stipa glareosa*), Дорнодын хялгана (*Stipa orientalis*), Кавказ хялгана (*Stipa caucasea*), Нангиад хазааргана (*Cleistogenes soongorica*) зонхилохоос гадна Таана (*Allium polyrrhizum*), Агь (*Artemisia frigida*), Нарийвтар шарилж (*Artemisia gracilescens*), Бор шаваг (*Artemisia xerophytica*), Төлөгчдүү боролзой (*Ajania achilleoides*), Дэлхээ тогторгоно (*Kochia prostrata*), Навчгүй баглуур (*Anabasis aphylla*), Бууралдуу янгиц (*Ptilotrichum canescens*), Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammanii*), Өргөст ортууз (*Oxytropis spinosa*), Цомцогт тэсэг (*Eurotia ceratoides*), Ямаан шарилж (*Artemisia scoraria*), Шүлхий шарилж (*Artemisia pectinata*) тааралдана.

Төсөл хэрэгжих орчмын ургамлын аймаг дахь овог төрлүүд харилцан адилгүй байгаа нь тухайн газар нутгийн экологийн байдалтай холбоотой. Энэ нь ургамлын зүйл бүрийн тархац экологи, тэдгээрийн үүсч хөгжсөн газар нутаг, орчин нөхцөл өөр өөр байдагтай уялдаатай юм.

Мод сөөг, заримдаг сөөг, сөөгөнцөр 24 зүйл, олон наст өвслөг ургамал 50 гаруй, нэг ба хокр наст ургамал 25 зүйл тус тус байна. Эдгээрийн амьдралын хэлбэрийг харахад говийн нөхцөлд голлон тохиолддог хэлбэрүүд юм. Тархаж буй ургамлын зүйлийн ихэнх нь хуурайсаг, хуурайсуу - чулуусаг, цөөнхи нь хужирсаг, хуурайсуу-чийгсэг экологийн бүлгүүд байгаа нь тухайн газар нутгийн экологийн онцлогтой холбоотой.

Унаган ургамал:

Судалгааны талбайн унаган ургамлуудад говийн хялгана /*Stipa gobica*/, хөмүүл сонгино /*Allium mongolicum*/ зэрэг ургамлууд хамаардаг. Эдгээр ургамлууд зонхлогчийн үүрэг гүйцэтгэхээ больсоноос гадна судалгааны явцад хайгуулын талбайнуудад мэр сэр бүртгэгдэж байлаа.

Үндсэндээ энэ орчимд нутгийн унаган ургамал маш ихээр бэлчээрийн талхагдалд орж сэргэн ургаж чадахгүйн улмаас арчигдаж баглуур, шаваг голчлон ургах болсон байна.

Ховор ургамал:

Байгалийн ургамлын тухай Монгол улсын хуулийн хавсралтанд 133 зүйл нэн ховор ургамал, Монгол улсын улаан номонд нэн ховор, ховор устах аюулд орж буй ургамал 100, засгийн газрын 1995оны 153 ба 165-р тогтоолын хавсралтанд 355 зүйл ховор ургамал орсон байдаг.

Амьтны аймаг:

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар Хойт говь, Говь-Алтай, Алтайн өвөр говийн тойрогт багтдаг. Ноён сумын нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын талбайн орчимд том хөхтөнөөс Янгир ямаа (*Capra sibirica*), Хавтгай тэмээ (*Camelus ferus*) тэмдэглэгдсэн байна. Жижиг хөхтөн, хор нутагтан ба мөлхөгчид зэрэг зарим амьтдын зүйлийн бүрдлийг харвал Цөлийн хөхтөний бүлгэмдэлээс Боролзон туулай (*Lepus tolai*), Элссэг зузга (*Phodopus roborovskii*), Бордуу шишүүхэй (*Cricetulus migratorius*), Шаргал чичүүл (*Meriones meridianus*), Морин цөцүүл (*Rhombomys opimus*), Шивэр алагдаага (*Allactaga sibirica*), Өмнөговийн алаг даага (*Allactaga balicunica*), Элсч савгадаахай (*Dipus sagitta*), Гувруу тажигдаахай (*Salpingotus crassicauda*) бий. Харин хоёр нутагтан ба мөлхөгчдийн бүлгэмдлээс Монгол бах (*Bufo raddei*), Цоохор хонин гүрвэл (*Phrynocephalus versicolor*), Тойрмын хонин гүрвэл (*Phrynocephalus helioscopus*), Нохой гүрвэл (*Teratoscincus Przewalskii*), Төмөр гүрвэл (*Alsophylax pipiens*), Говийн гүрвэл (*Eremias Przewalskii*), Могой гүрвэл (*E. multiocellata*), Загалт гүрвэл (*E. vermiculata*), Монгол гүрвэл (*E. argus*), Тэмээн сүүлт могой (*Eryx tataricus*), Сум могой (*Psammophis lineolatus*), Нарийн могой (*Coluber spinalis*), Рашааны могой (*Elaphe dione*), Бамбай хоншоорт могой (*Aqkistrodon halys*) тохиолдоно.

2.2 Төслийн гол ба болзошгүй нөлөөлөл:

“Баруун ноён уул” чулуун нүүрсний ордыг ашиглах төслийн БОННУ-ээр уурхайн үйл ажиллагааны гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Хүснэгт 2. Гол болон болзошгүй нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино ху гацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зэрэг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1. Байгалийн төрөл зүйн өөрчлөлт											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт	-				-	-			-	
2	Газрын доорх усны чанарын өөрчлөлт		-	-					-		
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт	-				-	-			-	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	-				-		-			-
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	-				-		-			-
6	Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт		-	-					-		
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			-					-		
2. Байгалийн нөөцийн ашиглалт											
8	Газрын гадаргын нөөц баялаг	-				-		-	-		
9	Бэлчээр, тэжээлийн байдал	-		-			-		-		
10	Эрдэс түүхий эд, нөөц	-				-		-			-
11	Эрчим хүчний нөөц										
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
12	Ундны усны чанар өөрчлөгдөх		-	-	-			-		-	
13	Ундны усны нөөц хомсдох		-	-						-	
14	Агаарын бохирдол	-			-					-	
15	Хөрсний бохирдол		-		-		-			-	

16	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		-			-	-			-	
17	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл	-			-					-	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор											
18	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх		-			-			-		-
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		-			-	-				-
20	Тусгай хамгаалалттай газар, нутагт нөлөөлөх										
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
22	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
5. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
23	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		+			+			+		+
24	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		+			+					+
25	Хүн амын орлого нэмэгдэж өөрчлөгдөх	+				+			+		+
26	Хүн амын тоо өөрчлөгдөх		-			-				-	
6. Эдийн засаг, байгаль орчин											
27	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх										
28	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+			+	+	
29	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+			+	+	
30	Ажлын байр нэмэгдэх	+				+			+	+	
31	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+				+	
32	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх										
7. Бусад нөлөөлөл											
33	Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	-				-			-		-
34	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтын усыг бохирдуулах	-				-				-	

35	Ахуйн хог, хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	-			-			-			-	
36	Хүчтэй салхи, тоосжилт	-			-							
Нөлөөллийн тоо ширхэг		Сөрөг	12	10	6	8	10	7	6	12	7	3
		Эерэг	5	2	0	1	6	0	5	4	3	0

Агаарын чанар:

- ❖ Хөрс хуулах, нүүрс олборлох үед үүсэх тоос
- ❖ Тээврийн хэрэгслийг явах үед боссон замын тоос
- ❖ Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтат хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хий
- ❖ Нүүрсний өөрөө шаталтаас үүссэн утаа болон хий
- ❖ Өрөмдлөг тэсэлгээний ажлын үед үүсэх тоос,
- ❖ Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос
- ❖ Нүүрс болон хөрсийг тээвэрлэх үед хийсэх тоос, шороо
- ❖ Зуухны яндангаас гарах утаа болон үнс, хорт хий зэрэг болно.

Хөрс:

Орчны үржил шимт хөрс болон малын бэлчээр уурхайн малталтанд орж, гадаад овоолгуудад дарагдахаас гадна хүнд даацын машин техникийн үйл ажиллагаанд өртөж эвдрэлд орно.

- ❖ Газрын нөөц хомсдох, ухагдаж ландшафтын өөрчлөлтөд орно
- ❖ Хөрсөн бүрхэвчийн морфологи тогтоц алдагдах, үржил шим нь буурах зэргээр шинж чанар нь өөрчлөгдөнө
- ❖ Хөрс усанд угаагдаж элэгдэнэ
- ❖ Газрын гадаргуугийн төрх байдал өөрчлөгдөж хоосон орой зай үүсэх зэргээр байгалийн төрх алдагдана
- ❖ Хөрс шороо дагтарших, шаваржих, зам харгуй үүсч хөрс талхлагдана

Усан орчин:

Төслөөс усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл бага байх бөгөөд уурхайн ШТМ хадгалах газар, ахуйн бохир ус, бие засах газраас нөлөөлөл учруулж болзошгүй. Уурхайн ашиглалтын явцад усны нөөцийг ашиглах мөн шавхан зайлуулснаар газар доорхи усны нөөцөд нөлөөлнө.

Ургамлан нөмрөг:

Ил уурхай, хөрс, чулуулгийн овоолго хийх, уурхайн барилга байгууламж дор дарагдах зэргээр ургамлан нөмрөг хөрс хуулалттай хамт хуулагдана. ШТМ-иар ургамлан нөмрөг бохирдож, төрөл зүйлийн бүрдэлд өөрчлөлт орохоос гадна уурхайн технологийн болон гадаад тээврийн замын хөдөлгөөнөөс үүссэн тоосжилтоор зам дагуух газрын ургамлан нөмрөг бохирдох, гадаад замын трасс дагуу газар тариалан эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн ургац тоос, шороонд дарагдаж бохирдох, улмаар ургацын чанарт сөргөөр нөлөөлнө.

Амьтны аймаг:

Автомашин, тээврийн хэрэгсэл, тэсэлгээний дуу чимээнээс ан амьтан үргэж дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьтдын амьдрах орон зай нь хумждах, уурхайн үйл ажиллагааг дагалдаж, хууль бусаар урхи, занга тавьж ан амьтан агнах, амьтны нөөц хорогдох, амьдрах орчин нь өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөтэй. Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаях, эвдэрсэн газрыг хөрсжүүлэх ажил орхигдоход хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын тоо толгой цөөрөх үйл явц ажиглагдана гэж тодорхойлсон.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛГО

Зорилго, зорилт: “Баруун ноён уул” уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2018 онд “ЭКОТАЙКҮҮН” ХХК-ийн боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг бүхий ажлууд, “Эхмонголын байгаль” ХХК-тай хамтран ажилласан биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах ажлын 5 жилийн төлөвлөгөөний эхний жилийн ажил, Өмнөговь аймгийн Ноён сумын иргэдийн хүсэлтийн дагуу “Цоохондойн задгай усыг сувагчлан засварлах, цөөрөм байгуулах” ажил, Байгаль орчны доройтол, цөлжилтийг бууруулах зорилгоор Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутагт 5000 мод бутыг тарих томоохон ажлуудыг тусгахаас гадна, Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийг зорино.

Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах;
- БОННУ-ний заалтуудыг хэрэгжүүлэх;
- “Хур эрдэнэ баялаг” ХХК-ийн байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх;
- 2023 оны БОМТ-д тусгагдсан ажлуудыг шат дараалалтай, бүрэн хийж гүйцэтгэх;

3.1 Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ:

Агаарын чанар, усан орчин, хөрсөн бүрхэвч, газрын гадарга, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, уурхайн үйл ажиллагаанаас нөлөөллөх нөлөөллийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд тогтмол усалгаа хийх;	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрс агуулах талбай;	тн/км	95.7528	200	19150.56	Тогтмол	Монгол Улсын Агаарын тухай хууль; MNS4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага;
		Тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар арчилгааг хийх, тэмдэг тэмдэглэгээг сайжруулан нэмэлтээр байршуулах;	Уурхайн технологийн зам, туслах зам;	км	1500	1	1500	Улиралд нэг удаа	
		Дотоод тээврийн зам болон технологийн зам дээр зорчих хөдөлгөөнд оролцож байгаа автомашин болон уулын хэсгийн техникүүдийн хөдөлгөөнд хурдны хяналт тавих,	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрс агуулах талбай;	км	*	*	*	Тогтмол	Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Замын

									аюулгүй байдлын тухай хууль;
		Ажилчдыг эрүүл ажиллах, амрах орчинг бүрдүүлэх зорилгоор уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, тоосжилтоос хамгаалан зүлэгжүүлэх;	Уурхайн тосгон;	м ²	5250	1	5250	Нэг удаа	MNS 6260:2020 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах;
2	Гадаргын болон газар доорхи ус	Уурхайн ундны усны хэрэгцээ тогтмол бүртгэх, ашиглах усны хэмжээг зорилгод түвшинд байлгах;	Уурхайн тосгон;	м ³	0.0997	5400	538.38	Тогтмол	Усны тухай” хууль, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS 4596:1998;
		Хөв цөөрөм байгуулах ажлын хийж гүйцэтгэх;	*	га	38000	1	38000	1 удаа	
		Уурхайн ногоон байгууламж усалгаанд зориулж ус ашиглах;	Уурхайн хэсэг;	га	0.79794	3333.3333 33	2659.8	2, 3-р улирал	
		Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах;	Уурхайн нийт ажилчдад;	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоогоор	100	2	200	Хагас жил тутам	
3	Хөрсөн бүрхэвч	Уурхайн олборлолтод өртөх талбайгаас шимт хөрсийг хамгаалах зорилгоор хадгалах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд;	га	*	3	*	Жилийн турш	5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт;

		талбайд стандартын дагуу овоолго үүсгэх;							
		ШТМ хөрсөнд алдагдахаас сэргийлэх;	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд;	л/м ²	2	1000	2000	Жилийн турш	
4	Газрын гадарга	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө" Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх";	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд;	м ²	*	*	*	Жилийн турш	"Хур эрдэнэ баялаг" ХХК-ийн " Газар хөндөх журам";
5	Ургамлан нөмрөг	Байгаль орчны доройтол, цөлжилтийг бууруулах зорилгоор Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд Баяндалай суманд мод тарих ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх;	*	Тарьж ургуулсан мод, бутны тоо ширхэгээр	*	5500	40000	2 болон 4-р улиралд	MNS 6140:2010 Техникийн шаардлага, MNS 6254:2011 Мод, сөөгний суулгацыг бойжуулах. Ерөнхий шаардлага;
6	Амьтны аймаг	Уурхайн үйл ажиллагаа явуулж буй газрын ойролцоо ховор зүйлд тооллогддог амьтдын тоо толгойд хяналт тавьж, мэдээг хөтлөх;	Уурхайн бүс;	*	1500	1	1500	1 удаа	Ноён сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагч нарын зөвлөмжийг үндэслэн зохион байгуулна;

		Ховор зүйлийн амьтдын хөл газарт улирлын нөхцлөөс хамааран биотехникийн аргаар хэмжээ авах;							
7	Нийт мян.төг								110798.74

3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө:

2019-2022 онд уурхайн олборлолтод өртсөн талбайн нийт 90000 м³ шимт болон шимэрхэг хөрсний овоолгыг 2022 оны 3 дугаар улиралд стандартын дагуу 3 метрээс өндөргүйгээр шилжүүлэн байршуулсан.

2023 онд уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбайн үйл ажиллагаанд өртөх шимт хөрсийг хуулж, овоолго үүсгэн, туршилтаар олон наст тариалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян. Төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	2	3	4	5	6	7	8	
1	Техникийн нөхөн сэргээлт	Уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбайн үйл ажиллагаанд өртөх шимт хөрсийг хуулж, тусгай талбайд овоолго үүсгэх;	га	*	*	*	*	5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт;
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолгыг салхины элэгдлээс хадгалж, хамгаалах зорилгоор олон наст ургамлыг туршилтаар тариалах	га	3	5000	15000	2, 3 дугаар улирал	MNS 5918:2008 Эвдэрсэн газрын ургамалжуулах техникийн шаардлага;
3	Нийт мян.төг							15000

3.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө:

2022 онд “Эхмонголын байгаль” ХХК-аар биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөг хийж гүйцэтгүүлсэн. Уг ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг, Цагаан толгойн талыг сонгон авч дүйцүүлэн хамгаалах ажлын арга хэмжээг шат дараалалтай хэрэгжүүлэхээр болсон.

Хүснэгт 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
	1	2	3	4	5	6	7	8
1	Цагаан толгойн зэрлэг ан амьтны тоо толгойд хяналт тавих;	Хяналт тавих;	Цагаан толгойн тал	*	*	*	Улиралд 1 удаа	Биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөний дагуу;
2	Цагаан толгойн талд нарны үүсгүүрээр автомат худаг гаргаснаар тухайн орчны хар сүүлт зээр амьдрах орчиндоо тогтвортой байрших нөхцөлийг бий болгох;	Нарны үүсгүүр бүхий худаг гаргах	Цагаан толгойн тал	1	30000	30000	Нэг удаа	MNS 6088:2011 Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага
3	Цагаан толгойн талын ургамлын аймаг, ургамлан бүрхэвчийг хамгаалах;	Үр түүж бэлтгэх, үрийг стандартын дагуу хадгалах, гарын авлага хэвлүүлэх;	Цагаан толгойн тал	3	5000	15000	2, 3-р улиралд	Биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөний дагуу
4	Нийт мян.төг							45000

3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө:

Уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд орж буй айлуудтай нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох гэрээг хийж гүйцэтгэсэн тул төлөвлөгөөнд оруулах шаардлагагүй.

Хүснэгт 6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт	
	1	2	3	4	5	6	7	8	
1	Айлууд	Нөхөн олговрын гэрээ хийгдсэн;	Уурхайн арга хэмжээний хүрээнд;	*	*	*	Нэг удаа;	Гэрээний дагуу;	
2	Нийт мян.төг								*

3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө:

“Хур эрдэнэ баялаг” ХХК-ийн “Баруун Ноён Уул” нүүрсний уурхайн лицензийн талбайд 2012 онд “Шинжлэх Ухааны Академи Археологийн Хүрээлэн” археологийн хайгуул хийгдэж, археологийн олдвор илрээгүй болно.

2023 онд “Монгол улсын соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн дагуу лицензийн талбайд Палеонтологийн судалгаа, Угсаатанзүйн судалгааг гэрээт компаниар хийлгэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
	1	2	3	4	5	6	7	8
1	Палеонтологийн судалгаа	*	*	1	5000	5000	*	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2	Угсаатанзүйн судалгаа	*	*	1	5000	5000	*	
3	Нийт мян.төг							10000

3.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө:

Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	2	3	4	5	6	7	8	
1	Техникүүдэд засвар үйлчилгээ хийх зориулалт бүхий ШТМ хадгалалт, тээвэрлэлт, асргалтанд	Засвар үйлчилгээний төвийн ШТМ-тай харьцаж байгаа хэсгүүдэд ил задгай асгаралтаас сэргийлэн бетондох;	Засвар үйлчилгээний хэсэг	1	3000	3000	1 удаа	Химийн хорт бодис аюултай бодисын тухай хууль
		ШТМ алдагдсан үед шингээгч, саармагжуулагч материалыг зохих газруудад байршуулах		*	2000	2000	Тогтмол	
2	Гал түймэр	Төслийн талбайд гал түймэр гарах эрсдэлээс сэргийлэх	Үйл ажиллагаа явуулж буй бүх барилга байгууламж	*	Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал		Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль
		Галын сургалт, семинар орох	Нийт ажилчдад	Сургалтанд суусан ажилчдын тоогоор			4 удаа	
3	Нийт мян.төг							5000

3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө:

Дахин ашиглах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах аж ахуй нэгжид тогтмол хүлээлгэн өгч, хог хаягдал ихээр хуримтлагдахаас сэргийлэн, хэсэг нэгжүүдийн хог хаягдал цуглуулах түр цэгт байнгын хяналт тавин ажиллана.

Ангилан ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг нэмж байршуулна.

Ажилтан, ажиллагсдыг хог хаягдлын зөв зохистой менежментийн талаар сургалт, семинарт тогтмол хамруулна.

Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хаягдал	Ахуйн хог хаягдлын цэгийг сайжруулах;	Уурхайн тосгон;	м ²	1000	1	1000	1 удаа	Хог хаягдлын тухай хууль;
		Ангилан ялгах зориулалт бүхий хогийн савны тоог нэмж байршуулах;	Уурхайн тосгон, гаалийн хяналтын хэсэг;	ширхэг	500	5	2500	1 удаа	
		Ахуйн хог хаягдал болон шингэн хаягдлын хадгалах, тээвэрлэх явцад хяналт тавих;	Уурхайн бүсээс устгал хийх талбай хүртэлх тээврийн замын хэсэг;	*	*	*	*	Тогтмол	Ачиж, зөөвөрлөх, устгах ажлыг хариуцаж авсан орон нутгийн компанитай хийсэн гэрээний дагуу;

2	Үйлдвэрийн хаягдал	Хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг нэг цэгт төвлөрүүлэх талбайг тохижуулах;	Засвар үйлчилгээний хэсэг;	м ²	*	1	1500	1 удаа	Хог хаягдлын тухай хууль;
3	Аюултай хог хаягдал	Засвар үйлчилгээний төвд ангилан ялгах түр хогийн цэгүүдийг байрлуулах;		*	*	3	1000	1 удаа	Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт бодис аюултай бодисын тухай хууль;
4	Нийт мян.төг								6000

3.8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр:

“Баруун ноён уул” нүүрсний уурхайн талбай нь Монгол орны уур амьсгалын мужлалаар гандуу дулаан зунтай бүсийн, хүйтэн өвөлтэй мужид байрладаг. Энэ ч утгаараа бусад бүс нутгуудтай харьцуулахад хур тунадас бага, хуурайшилт ихтэй, салхины хурд өндөр байдгаас нөлөөлж тоосжилт үүсэх байгалийн суурь нөхцөлтэйгөөс гадна уурхайлах үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүссэн тоосжилт бий болдог. Төсөл хэрэгжих газрын агаарын чанарт уурхайн үйл ажиллагаанаас нам болон өндөрт нөлөөлж буй нөлөөллийг ашиглалтын явцад тоосонцор хэмжигч гар багаж ашиглан тогтмол хяналт шинжилгээ хийх бөгөөд мөн ус болон хөрсний хяналтын цэгүүдийн тоо, байрлалыг 2020, 2021, 2022 онуудад хийж байсан суурь цэгүүдэд үргэлжлүүлэн хэмжилт хийх, итгэмжлэгдсэн лабораториудад сорьцуудыг шинжлүүлэхээр тусгасан.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян. төг	Нийт зардал мян. төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
Агаар чанар тоосны мониторинг	Уурхайн хэсэг, Засвар үйлчилгээний төв, уурхайн тосгон, Гаалийн хяналтын бүс	Долоо хоног бүр	Сард 4 удаа	*	*	Дотоод үйл ажиллагаа	Байгаль орчны зохих хууль тогтоомж, стандартууд
Худгийн түвшин хэмжилт	Худгийн усыг хэмжих багаж	*	1	4500	4500		
	Малчны гар худагт /2худаг/	Сар бүр	Жилд 12 удаа	*	*	Дотоод үйл ажиллагаа	
Цооногийн түвшин хэмжигч		Сар бүр	12	3000	3000		

<p>Агаарын шинжилгээ Тоосонцорын шинжилгээ Дуу чимээ, физик бохирдлыг хэмжих O₂, SO₂, NO₂, CO Бага хурдтай дээжлэгч</p>	<p>Уурхайн карьер, Шатахуун түгээх станц, Засвар үйлчилгээний төв, Уурхайн тосгон</p>	<p>3 дугаар улирал</p>	<p>1</p>	<p>3,000</p>	<p>3,000</p>	<p>Гэрээт лабораторид шинжлүүлнэ</p>	<p>MNS 3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага, MNS 5061:2001. Нүүрс Хүчлийн хий-CO₂ тодорхойлох эзэлхүүний арга, MNS 0012-1-015:1987. Чимээ шуугиан-Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга, MNS0017.2.5.11-1998. Азотын давхар исэл</p>
<p>Усны шинжилгээ Бактериологийн бүрэн шинжилгээ, Усны ерөнхий химийн шинжилгээ</p>	<p>Унд ахуйн худаг, хоол үйлдвэрлэлийн хэсэг, нийтийн ариун цэврийн өрөө</p>	<p>2,3,4-р дүгээр улиралд</p>	<p>3</p>	<p>300</p>	<p>900</p>	<p>.</p>	<p>MNS 0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага чанар, аюулгүй байдлын үнэлгээ</p>
<p>Хөрсний шинжилгээ Хүнд металлийн шинжилгээ,</p>	<p>Уурхайн карьер, Шатахуун түгээх станц, Засвар үйлчилгээний төв, Уурхайн тосгон</p>	<p>3 дугаар улирал</p>	<p>2</p>	<p>580</p>	<p>1,160</p>		<p>MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ</p>
<p>Нийт мян.төг</p>							<p>12,560</p>

3.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө:

Удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нь БОМТ–ий хэрэгжилтэнд чухал ач холбогдолтой. БОМТ-ий хэрэгжилтийг хангахад зөвхөн байгаль орчны мэргэжилтэн бус хэсэг нэгжийн ажилтнуудын оролцоо шаардагддаг. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт оролцооны хэлбэр, тодорхойлон хэрэгжилтийг хангахад чиглэнэ.

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /мян. төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар 4	Сар 8	Сар 11		
1	2	3	4	5	6	7	
1	Байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг төлөвлөгөөндөө тусган орон нутгийн байгууллага болон байгаль хамгаалах клубуутай хамтран зохион байгуулах;	2000				Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн;	Байгаль хамгаалах хавар, намрын сарын аян, Цөлжилттэй тэмцэх өдөр, Дэлхийн усны өдөр, Биологийн олон янз байдлыг хамгаалах өдрүүдийг тэмдэглэх;

2	Уурхайн ажилчдын байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг сайжруулан, сургалт семинарыг тогтмол орох;	500				Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн;	Улирал бүр байгаль орчныг хамгаалах ажлын хүрээнд сургалт семинар орох;
3	Нийт						2,500

3.10 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө:

Хүснэгт 12. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян. төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Ноён сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагчид шаардлагатай мэдээ тайланг хүргүүлэх /ус ашиглалт, хог хаягдал/	Танилцуулга	Мэдээ тайлангууд	Улиралд 1 удаа	*	*	*
2	Иргэдийн төлөөлөл, шалгалтын комисс	Танилцуулга	Биелэлтийн тайлан	12 сар	500		
3	Нийт						500

Хүснэгт 13. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	110,799
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал	15,000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	45,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний зардал	*
5	Түүх соёлын өвийг хамгаалах	10,000
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	5,000
7	Хог хаягдлын менежментийн зардал	6,000
8	Удирдлага төлөвлөгөөний зохион байгуулалтын зардал	2,500
9	Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний зардал	12,560
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал	500
11	Нийт зардал мян.төг	207,359